

ГАРЧИГ

1.	ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ	1
1.1	Төслийн ерөнхий мэдээлэл	1
1.1.1	Төсөл хэрэгжүүлэгчийн тухай товч мэдээлэл.....	1
1.1.2	Төслийн байршил, газар ашиглалтын тодорхойлолт	1
1.1.3	Цагаанчулуутын ам уурхайн өнөөгийн байдал	3
1.1.4	Төслийн үйл ажиллагаа, удирдлага, зохион байгуулалт	6
1.2	Ашигт малтмалын ордын тодорхойлолт	7
1.2.1	Ордын нөөц	7
1.2.2	Ордын нөөцийн тооцоо.....	7
1.3	Ил уурхайн төлөвлөлт	8
1.3.1	Төслийн хүчин чадал.....	8
1.3.2	Ил уурхайн ажлын горим.....	9
1.3.3	Ил уурхайн уулын ажлын календарьчилсан төлөвлөгөө.....	10
1.3.4	Элс олборлолтын төлөвлөгөө	11
1.3.5	Ил уурхайн ашиглалтын технологи.....	11
1.3.6	Ил уурхайн уулын ажлын механикжуулалт	12
1.4	Баяжуулалтын технологи.....	12
1.4.1	Элс угааж, баяжуулах технологи	12
1.4.2	Баяжуулах хэсгийн тоног төхөөрөмж.....	13
1.5	Дэд бүтэц	1
2.	ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	4
3.	ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ.....	9
4.	ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАМРАХ ХҮРЭЭ.....	11
5.	СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	12
6.	НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	18
6.1	Уурхайн хаалт	19
7.	БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	23
8.	НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	25
9.	ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	26
10.	ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	27

11.	ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	29
12.	ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	31
13.	БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	34
14.	ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ	36

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн тусгай зөвшөөрлийн талбайн байршлын зураг.....	2
Зураг 2 Ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийн талбайн зураг.....	3
Зураг 5 MV-001817 ашиглалтын талбайн өнөөгийн төлөв байдал орто фото зураг DJI Air 3 drone 2024-04-03	4
Зураг 6 MV-001817 ашиглалтын талбайн өнөөгийн төлөв байдал орто фото зураг DJI Air 3 drone 2024-04-03	5
Зураг 7 MV-006428 ашиглалтын талбайн өнөөгийн төлөв байдал орто фото зураг DJI Air 3 drone 2024-04-03	6
Зураг 8. Уурхайн удирдлага зохион байгуулалтын бүтэц.....	7
Зураг 9 Цагаан чулуут тусгай зөвшөөрлийн талбайн нөөцийн хэсэгшилүүд	8
Зураг 10 Ил уурхайн ажлын горим	10
Зураг 11 Уулын ажлын календарьчилсан төлөвлөгөө	11

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. MV-016901 тоот тусгай зөвшөөрлийн булангийн цэгүүд	1
Хүснэгт 2 MV-006428 тоот тусгай зөвшөөрлийн талбайн булангийн цэгүүд.....	1
Хүснэгт 3 Төслийн талбайн ашиглалт	4
Хүснэгт 4 Ордын нөөцийн тооцооны нэгдсэн хүснэгт (Ордын нөөц 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар).....	8
Хүснэгт 5. Ил уурхайн ажлын горим.....	9
Хүснэгт 6. Ил уурхай- 1 Уулын ажлын календарьчилсан төлөвлөгөө.....	10
Хүснэгт 7 Ил уурхайн ашиглалтын технологийн схем	11
Хүснэгт 8. Ил уурхайд ажиллах үндсэн техникийн тоо	12
Хүснэгт 9. Сонгосон скруббер бутарын техникийн үзүүлэлт.....	13
Хүснэгт 10. Баяжуулах ширээний техникийн үзүүлэлт.....	13
Хүснэгт 11. Усны насосын техникийн үзүүлэлт	14
Хүснэгт 12. Төслийн нийт цахилгааны хэрэглээ	2
Хүснэгт 13. Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт	9
Хүснэгт 14. 2026 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал.11	
Хүснэгт 15. Сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	12
Хүснэгт 16. Нөхөн сэргээлтийн зардал	18
Хүснэгт 17. Уурхайн хаалт хийхэд анхаарах гол асуудлууд.....	20
Хүснэгт 18. Биологийн нөхөн сэргээлтийн хяналт, мониторинг хийх хугацаа	22
Хүснэгт 19. Биологийн нөхөн сэргээлтийн хяналт, мониторингийн давтамж.....	22
Хүснэгт 21. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	23
Хүснэгт 22. Төслийн талбайн ойр орших өвөлжөө хаваржаа . Error! Bookmark not defined.	
Хүснэгт 23. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	26
Хүснэгт 24. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	27
Хүснэгт 25. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	29
Хүснэгт 26. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	31
Хүснэгт 27. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	34

1. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1.1 Төслийн ерөнхий мэдээлэл

1.1.1 Төсөл хэрэгжүүлэгчийн тухай товч мэдээлэл

Төслийн нэр :	Цагаанчулуутын амны алтны шороон ордыг ил аргаар ашиглах төсөл
Төсөл хэрэгжүүлэгч :	“Сонор трейд” ХХК, Улсын бүртгэлийн дугаар: 9011196033 Регистрийн дугаар: 2590565 Хариуцлагын хэлбэр “Хязгаарлагдмал хариуцлагатай компани” Тусгай зөвшөөрлийн дугаар : MV-001817, MV-006428
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Залуучдын өргөн чөлөө, Сонор плаза Утас1: 99214188 Утас2: 311029

Үндсэн үйл ажиллагаа. “Сонор трейд” ХХК нь Улсын бүртгэлийн гэрчилгээгээр 132000 кодтой “Ашигт малтмал ашиглах” үндсэн үйл ажиллагаатай.

1.1.2 Төслийн байршил, газар ашиглалтын тодорхойлолт

Ашиглалтын хоёр талбай нь Сэлэнгэ аймгийн Баянгол сумын нутаг орших бөгөөд сумын төвөөс урд зүгт 18км, Улаанбаатар-Дархан- Сэлэнгэ чиглэлийн хатуу хучилттай замаас зүүн зүгт 3км, Зүүнхараа чиглэлийн хатуу хучилттай зам талбай дундуур дайран өнгөрдөг бөгөөд Улаанбаатар хотоос хойш 135км зайд байрладаг.

Газарзүйн солбицол:


Хүснэгт 1. MV-001817 тоот тусгай зөвшөөрлийн булангийн цэгүүд

Орд	Хэмжээ /га/	№	Урттраг			Өргөрөг		
			градус	минут	секунд	градус	минут	секунд
Цагаан чулуутын ам	25.24	1	106	11	20.2	48	42	9.87
		2	106	11	20.2	48	42	25.87
		3	106	10	55.2	48	42	25.87
		4	106	10	55.2	48	42	9.87

Хүснэгт 2 MV-006428 тоот тусгай зөвшөөрлийн талбайн булангийн цэгүүд

Орд	Хэмжээ /га/	№	Урттраг			Өргөрөг		
			градус	минут	секунд	градус	минут	секунд
Цагаан чулуутын ам	147.04	1	106	12	9.2	48	42	25.87
		2	106	11	20.2	48	42	25.87
		3	106	11	20.2	48	42	9.87
		4	106	10	55.2	48	42	9.87
		5	106	10	55.2	48	42	25.87
		6	106	10	50.19	48	42	25.87
		7	106	10	50.19	48	41	44.86
		8	106	11	39.2	48	41	44.86
		9	106	11	39.2	48	42	1.88
		10	106	12	9.2	48	42	1.88

Сэлэнгэ аймгийн Баянгол сумын нутагт орших “Сонор трейд” ХХК-ийн MV-001817, MV-006428 тоот тусгай зөвшөөрөлтэй “Цагаанчулуутын ам” алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2026 он




Зураг 1. Төслийн тусгай зөвшөөрлийн талбайн байршлын зураг


Төслийн талбайн байршлын тодорхойлолт. Төслийн талбайн байршлыг хуулиар хамгаалсан газар нутаг байгаа эсэхийг БОАЖЯамны /хуучин нэрээр/Ой, ус, тусгай хамгаалалттай газрын кадастрын хэлтэс-т хандан тодорхойлуулснаас гадна <https://eic.mn/> сайтын газар мэдээллийн зурагтай давхцуулснаар БОННУ-ний хүрээнд нэмэлт судалгаа хийж дараах нөхцөлүүдийг тогтоосон.

Сэлэнгэ аймгийн Баянгол сумын нутагт орших “Сонор трейд” ХХК-ийн MV-001817, MV-006428 тоот тусгай зөвшөөрөлтэй “Цагаанчулуутын ам” алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2026 он

Цагаанчулуутын-Ам | Цагаанчулуут



Цагаан чулуутын ам



Зураг 2 Ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийн талбайн зураг

Засгийн газрын 2012 оны 194, 2015 оны 289-р тогтоолоор батлагдсан гол, мөрний урсац бүрэлдэх эхтэй давхцалгүй, ойн сантай давхцалгүй, усны сан бүхий газрын хамгаалалтын бүстэй давхцалгүй, улсын тусгай хамгаалалттай газар нутагтай давхцалгүй байна. Орон нутгийн усны энгийн болон онцгой хамгаалалтын бүстэй давхцалгүй байна.

1.1.3 Цагаанчулуутын ам уурхайн өнөөгийн байдал


Төслийн талбай ашиглалтын тодорхойлолт. Төслийн талбайд өнөөгийн байдлаар хатуу хучилттай авто зам, технологийн зам талбай, кемп, техникийн нөхөн сэргээлт хийсэн уурхайн овоолго, хайгуулын үеийн нөлөөлөл зэрэгт өртсөн талбай 25.5 га буюу нийт талбайн 15% эзэлж байна.

Хүснэгт 3 Төслийн талбайн ашиглалт

№	Хөрсөн бүрхэвчид нөлөөлж буй газар ашиглалтын төрөл	Талбай, га
1	Спорт талбай	0.02
2	Хатуу хучилттай зам	3.80
3	Зам барих үеийн нөлөөлөлд өртсөн	1.74
4	Хайгуулын үеийн нөлөөлөлд өртсөн	0.67
5	Технологийн зам талбай	5.06
6	Кемпийн байгууламж	1.30
7	Шимт хөрсний овоолго	0.97
8	Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбай	3.85
9	Биологийн нөхөн сэргээлт хийсэн талбай	1.51
10	Тэсрэх агуулах	0.91
11	Хаягдал шороо овоолго	2.33
12	Баяжуулах үйлдвэр	0.07
13	Засварын талбай	0.19
14	Карьер	2.91
15	Үүсмэл цөөрөм	0.15
Нийт:		25.5



Зураг 3 MV-001817 ашиглалтын талбайн өнөөгийн төлөв байдал орто фото зураг DJI Air 3 drone 2024-04-03



Зураг 4 MV-001817 ашиглалтын талбайн өнөөгийн төлөв байдал орто фото зураг DJI Air 3 drone 2024-04-03



Зураг 5 MV-006428 ашиглалтын талбайн өнөөгийн төлөв байдал орто фото зураг DJI Air 3 drone 2024-04-03

1.1.4 Төслийн үйл ажиллагаа, удирдлага, зохион байгуулалт

Төсөлд шаардлагатай хүний нөөц. Хариуцлагатай албан тушаалууд болох ИТА нарын ажлын байранд салбартаа болон компанидаа олон жил ажилласан мэргэжлийн боловсон хүчнүүдийг бүрдүүлж, бусад ажлын байрууд дээр шаардлагатай тохиолдолд шинэ, залуу боловсон хүчнүүдийг авч сургаж дагалдуулан ажиллуулж багийн чадавхыг тасралтгүй нэмэгдүүлэн ажиллаж байна.

Ил уурхайн ажилчид 14/14 хоногийн ВАХТ-ын системээр ажиллах ба хоногт 2 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг байна. Орд ашиглалтын 2 жилийн хугацаанд нийт 45 хүнийг ажлын байраар хангана.



Зураг 6. Уурхайн удирдлага зохион байгуулалтын бүтэц

1.2 Ашигт малтмалын ордын тодорхойлолт

1.2.1 Ордын нөөц

Цагаан чулуутын алтны шороон ордын дээд давхаргын нийт нөөц (В+С) зэргээр 294.16 мг/куб.м дундаж агуулгатай 295.88 мян.куб.м элсэнд 87.04 кг /химийн цэврээр 72.80 кг/ алт, бодитой (В) зэргээр 306.2 мг/куб.м дундаж агуулгатай 264.61 мян.куб.м элсэнд 81.02 кг /химийн цэврээр 67.77 кг/ алт, боломжтой (С) зэргээр 192.32 мг/куб.м дундаж агуулгатай 31.27 мян.куб.м элсэнд 6.01 кг /химийн цэврээр 5.03 кг/ алт байна.

Цагаан чулуутын алтны шороон ордын дунд 1 давхаргын нийт нөөц (В+С) зэргээр 310.76 мг/куб.м дундаж агуулгатай 30.64 мян.куб.м элсэнд 9.52 кг /химийн цэврээр 7.97 кг/ алт, бодитой (В) зэргээр 305.66 мг/куб.м дундаж агуулгатай 17.99 мян.куб.м элсэнд 5.5 кг /химийн цэврээр 4.6 кг/ алт, боломжтой (С) зэргээр 318.01 мг/куб.м дундаж агуулгатай 12.65 мян.куб.м элсэнд 4.02 кг /химийн цэврээр 3.37 кг/ алт байна.


Цагаан чулуутын алтны шороон ордын дунд 2 давхаргын нийт нөөц боломжтой (С) зэргээр 247.75 мг/куб.м дундаж агуулгатай 6.6 мян.куб.м элсэнд 1.63 кг /химийн цэврээр 1.37 кг/ алт байна. Орд нь III бүлгийн шороон ордод хамаарна.

1.2.2 Ордын нөөцийн тооцоо

Цагаанчулуут алтны шороон ордын нөөцийн тооцоонд 2024 оны цохилтот өрмийн үр дүнгээр 294.77 мг/м³ дундаж агуулгатай 333.12 мян.м³ элсэнд шлихээр (В+С) зэргээр 98.19 кг /химийн цэврээр 82.14 кг/ алтны нөөц тооцжээ. Орд нь III бүлгийн шороон ордод хамаарна.

Хүснэгт 4 Ордын нөөцийн тооцооны нэгдсэн хүснэгт (Ордын нөөц 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар)

№	2024 оны 12 дүгээр сарын 01 байдлаарх нөөц								
	Блокийн дугаар	Талбай мян.м ²	Давхаргын зузаан м		Дундаж агуулга мг/м ³	Эзэлхүүн.мян.м ³		Алтны нөөц кг	
			Хөрс	Элс		Хөрс	Элс	Шлих	Хими цэвэр
1	1-С-1	4.42	2.10	2.13	284.86	9.29	9.40	2.68	2.24
2	1-В-2	16.95	3.89	2.74	267.90	65.86	46.49	12.45	10.42
3	1-В-3	15.84	9.38	2.37	277.45	148.53	37.48	10.40	8.70
4	1-С-4	9.46	11.65	1.60	134.71	110.27	15.14	2.04	1.71
5	1-В-5	28.93	9.34	1.60	399.71	270.25	46.29	18.50	15.48
6	1-В-6	35.40	10.12	1.29	290.34	358.17	45.81	13.30	11.13
7	1-В-7	25.30	9.60	1.50	318.94	242.88	37.95	12.10	10.12
8	1-В-8	15.21	6.95	1.65	298.95	105.74	25.10	7.50	6.28
9	1-В-9	13.12	6.63	1.94	265.17	86.95	25.48	6.76	5.65
10	1-С-10	2.97	6.93	2.27	192.69	20.58	6.73	1.30	1.08
11	2-С-11	3.15	13.90	0.90	678.06	43.84	2.84	1.92	1.61
12	2-В-12	13.84	18.49	1.30	305.66	255.86	17.99	5.50	4.60
13	2-С-13	6.72	20.32	1.46	213.84	136.56	9.81	2.10	1.76
14	3-С-14	2.27	2.90	2.90	247.75	57.32	6.60	1.63	1.37
Нийт дүн		193.60	9.44	1.83	294.77	1,912.08	333.12	98.19	82.14



Зураг 7 Цагаан чулуут тусгай зөвшөөрлийн талбайн нөөцийн хэсэгшилүүд

1.3 Ил уурхайн төлөвлөлт

1.3.1 Төслийн хүчин чадал

Уурхайн хүчин чадлыг захиалагч компаниас өгсөн ажлын даалгаврын дагуу элс баяжуулах цехийн хүчин чадал болон компанийн олборлолтод ажиллах техникүүдийн хүчин чадалтай уялдуулан тооцсон. Тус даалгавраар “Цагаан чулуут” ордын 2025 оны 01

сарын 01 ний байдлаар нөөцөд тулгуурлан ТЭЗҮ боловсруулахад үйлдвэрлэлийн нөөц, ажлын горимоос хамааруулан төлөвлөв.

Ил уурхайн нийт ажиллах жилийг дараах байдлаар тодорхойлно. Үүнд:

$$T_{\text{жил}} = Q_a / AГ$$

Энд: Q_a – ашиглалтын нөөц, мян.м³

$AГ$ – уурхайн олборлолтын жилийн дундаж хүчин чадал, мян.м³

Алтны шороон ордын хувьд $T = 396.55 \text{ мян.м}^3 / 220.0 \text{ мян.м}^3 = 1.8 \approx 2$ жил болж байна. Иймээс ил уурхайн нийт ажиллах хугацааг 2 жил, хаалт нөхөн сэргээлтийн ажлыг 3 дахь жилд хийхээр төлөвлөж ТЭЗҮ-н тооцоог боловсруулав.


1.3.2 Ил уурхайн ажлын горим

Ил уурхайн ажилчид 14/14 хоногийн ВАХТ-ын системээр ажиллах ба хоногт 2 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг байна. Уурхайн эхний жилд хөрс хуулалтын ажлыг 4-р сараас 11-р сар хүртэл, элс баяжуулалтын ажлыг 5-р сарын эхлэн 10-р сарыг дуустал, үргэлжлэхээр тооцоолж ТЭЗҮ боловсруулав.

Уурхайн хөрс хуулалтыг дотоод овоолго үүсгэн хуулах бөгөөд уурхайн ашиглалтаар эвдрэлд өртсөн талбайд жил бүр техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг хийж хийхээр төлөвлөв. Уулын ажил нь цаг агаарын саатал, төлөвлөгдөөгүй техникийн засвар үйлчилгээ, сул зогсолтоос хамааран эхний жилд баяр ёслол, амралтын өдрүүд 7 хоног, цаг агаараас хамаарсан сул зогсолт 14, уурхайн жилд ажиллах бодит хоног 190 хоног тус тус ажиллахаар байна.

Хүснэгт 5. Ил уурхайн ажлын горим

Д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	II-жилд
1	Календарийн хоног	хоног	211
2	Баяр ёслол, амралтын өдрүүд	хоног	7
3	Цаг агаараас хамаарсан сул зогсолт	хоног	14
4	Уурхайн жилд ажиллах бодит хоног	хоног	190
5	Хоногт ажиллах ээлжийн тоо	-	2
6	Ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	12
7	Ээлжийн сул зогсолт (цайны цаг)	цаг	1
8	Ээлжийн сул зогсолт (ээлж солилт, түлш тос, солилт)	цаг	1
9	Ээлжийн цаг ашиглалтын коэффициент	-	0.84
10	Уурхайн жилд ажиллах бодит цаг	цаг	20



Зураг 8 Ил уурхайн ажлын горим

1.3.3 Ил уурхайн уулын ажлын календарьчилсан төлөвлөгөө


Ил уурхайн календарьчилсан төлөвлөгөөг төсөл захиалагч компаниас өгсөн ажлын даалгаврын дагуу ажиллахаар төлөвлөсөн.

Календарьчилсан төлөвлөгөө

Ордын уулын ажлын календарьчилсан төлөвлөлтийг ордын уул геологийн нөхцөл, элс угаан баяжуулах хэсгийн хүчин чадал болон олборлолтод ажиллах техникүүдийн хүчин чадалд тулгуурлан боловсруулав. Ил уурхай нь ашиглалтын 2 жилийн хугацаанд нийт 2,486.37 мян.м³ уулын цул үүнээс 396.55 мян.м³ элс олборлож, 2,089.82 мян.м³ хөрс хуулна. Хөрс хуулалтын дундаж коэффициент 5.27 м³/м³ байна.

Хүснэгт 6. Ил уурхай- 1 Уулын ажлын календарьчилсан төлөвлөгөө

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	I-р жилд	II-р жилд	Нийт
Ил уурхай					
1	Шимт хөрс хуулалт	мян.м ³	39.19	38.25	77.44
2	Хөрс хуулалт	мян.м ³	1,005.62	865.51	1,871.13
3	Баяжуулахын нуур далан	мян.м ³	87.50	53.75	141.25
4	Нийт хөрс хуулалт	мян.м ³	1,132	958	2,089.82
5	Элс олборлолт	мян.м ³	219.4	177.15	396.55
6	Уулын цул	м ³ /м ³	1,351.70	1,134.67	2,486.37
7	Хөрс хуулалтын коэффициент	м ³ /м ³	5.16	5.41	5.27
Баяжуулах цех					
1	Угаах элсний хэмжээ	мян.м ³	219.4	177.2	396.55
2	Дундаж агуулга	мг/м ³	233.22	248.04	239.84
3	Бүтээгдэхүүн гаргалт	Шлих кг	45.4	39.0	84.4



Зураг 9 Уулын ажлын календарьчилсан төлөвлөгөө

1.3.4 Элс олборлолтын төлөвлөгөө

Цагаан чулуут алтны шороон орд ордын элс олборлолтын төлөвлөгөөг төсөл захиалагчаас ирүүлсэн ТЭЗҮ боловсруулах техникийн ажлын даалгавар, угаан баяжуулах хэсгийн хүчин чадалд тулгуурлан ашиглалтын 2 жилд нийт 396.55 мян.м³ элс олборлох ба үүнээс ашиглалтын эхний жилд 219.4 мян.м³, хоёр дох жилд 177.15 мян.м³ элс тус тус олборлоно.

1.3.5 Ил уурхайн ашиглалтын технологи

Цагаан чулуутын амны алтны шороон ордын элсний (ашигт) давхарга сунаж тогтсон ба давхаргын өргөн дунджаар 133.7 м болно. Ордын хөрс хуулалтын зузаан дунджаар 11.03 м тогтоосон. Ашигт (элсний) давхаргын зузаан дунджаар 1.83 м байна.

Алт агуулсан давхарга элс, шаварлаг элсэрхэг дүүргэгчтэй, аллювиаль-пролювиаль хурдсаар дүүргэгдсэн. Алттай давхарга нь олон жилийн хөлдүү хөрсгүй. Ордын ашигт давхаргыг бүрдүүлэгч хурдасны литологийн найрлагат шаварлаг хольцын агуулга 10 %-иас ихгүй учир элсний угаагдах чанар сайтай.

Дурдсан үзүүлэлтүүд ба ордын уул-геологийн нөхцөл Цагаан чулуутын амны алтны шороон ордын ашиглалт явуулахад боломжтой, уул-техникийн энгийн нөхцөлтэй гэж үзнэ. Дунд болон том хэмжээний бул чулуугүй, цэвдэгшил байхгүй, алттай давхаргын угаагдах чанар сайн, хана нурангигүй, хөрсний шүүрлийн ус бага зэргээс үзвэл тус алтны шороон орд нь уул техникийн хувьд таатай нөхцөлтэй орд юм.

Хүснэгт 7 Ил уурхайн ашиглалтын технологийн схем

Технологи	Үндсэн ажил	Технологийн процессууд
Авто	1. Хөрс хуулалт	1.1. Ухаж ачих
		1.2. Тээвэрлэх

тээвэртэй		1.3. Овоолох
ашиглалтын		2.1. Ухаж ачих
технологи	2. Элс олборлолт	2.2. Тээвэрлэх
		2.3. Овоолох

1.3.6 Ил уурхайн уулын ажлын механикжуулалт

Орд ашиглалтын 2 жилийн хугацаанд нийт Ил уурхай нь ашиглалтын 2 жилийн хугацаанд нийт 2,486.37 мян.м³ уулын цул үүнээс 396.55 мян.м³ элс олборлож, 2,089.82 мян.м³ хөрс хуулна. Хөрс хуулалтын дундаж коэффициент 5.27 м³/м³ байна.

Тус ордыг компани өөрийн техникээр олборлох бөгөөд компанийн ажиллах ажиллах үндсэн техникийн тоо авч үзвэл:

Хүснэгт 8. Ил уурхайд ажиллах үндсэн техникийн тоо

Д / д	Тоног Төхөөрөмж	Марк	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Утга	Тоо ширхэг	
						I-р жилд	II-р жилд
1	Экскаватор	Hyundai-520 LC	Утгуурын багтаамж	м ³	3.2	1	1
2	Экскаватор	Hyundai-520 LC	Утгуурын багтаамж	м ³	3.2	1	1
3	Утгуурт ачигч	XZ656L	Утгуурын багтаамж	м ³	3.0	1	1
4	Бульдозер	D65A	Хусуурын хамах чадвар	м ³	9.0	1	1
5	Авто самосвал	HOW-336	Техникийн даац	тн	25	6	6
6	Гэрэлт цамхаг	Terex RL4	Хөдөлгүүрийн чадал	кВт	6	1	1

1.4 Баяжуулалтын технологи

Алт агуулсан элсний угаагдах шинж чанарыг тодорхойлох туршилт

2024 онд тусгай зөвшөөрлийн талбайд ордыг төлөөлөх 3 шурф малтаж дээд давхаргаас бөөний сорьц авч Геологийн Судалгаа Шинжилгээний Төв ТӨҮГ-т алт агуулагч давхаргын эрдэслэг бүрэлдэхүүний шинжилгээ, баяжигдах шинж чанар, технологийн туршилт зэрэг ажлуудыг хийлгэсэн.

1.4.1 Элс угааж, баяжуулах технологи

Угаан баяжуулах технологийн сонголт

Ордын элс угаан баяжуулах технологийн горимыг юуны өмнө шаварлаг эрдсийн хэмжээ, алтны оршин тогтсон хэлбэр, ялангуяа алтны ширхэгийн хэмжээ, мөлгөржилт зэрэг олон үзүүлэлтээс хамааруулан гаргалаа.

Элсний угаагдах чадвар хялбар, жижиг ангиллын алт агуулсан байгаа нь гравитацийн баяжуулалтын энгийн, боловсронгуй технологи хэрэглэхэд тохиромжтойг туршилт, шинжилгээний үр дүнгүүд харуулж байна. Гэхдээ алтны хаягдал багатай, эдийн засгийн үр ашигтай, орчин үеийн технологийг ашиглах нь илүү ач холбогдолтой болно. Шлюзийн боловсронгуй технологийг хэрэглэхэд металлын алдагдал бага, авалт өндөртэй байгааг сүүлийн үеийн практик үйл ажиллагаа харуулж байгаа. Үүнд баяжуулах ширээ, төвөөс зугтах хүчний сепараторуудыг шлюзтэй хослуулах нь зүйтэй гэж үзэв. Шигшүүрийн шинжилгээний үр дүнгээс үзэхэд алтны баяжигдах чанар сайн бөгөөд 0.25 мм, түүнээс том

фракцын алт 50% -иас их байгаа нь угаах төхөөрөмжөөр баяжуулах боломжтойг харуулж байна.

Эндээс ордын элсний угаагдах чанар, алтны хэмжээ болон техник эдийн засгийн үзүүлэлтүүдийг харьцуулан авч үзвэл ордын ашиглалтын үед элсний алтыг 90%-иас доошгүй гарган авах боломжтой.

Угаан баяжуулах хэсгийн технологийн горим

ГТЛ-ийн элс баяжуулах технологийн туршилт, шинжилгээний үр дүнг үндэслэн шороон ордын бага агуулгатай элс баяжуулахад тохирох алт олборлолт ба өртгийг өсгөх ямар нэгэн тусгайлсан төхөөрөмж ашиглахгүйгээр хамгийн энгийн технологийн горимыг сонгов.

Иймээс скруббер-бутар, гүн, нам дүүргэлтийн шлюзийн угаах төхөөрөмжийг сонгон ашиглахаар ТЭЗҮ-д тусгалаа. Тус ордын элс баяжуулах технологийн горимыг 2 үе шатаар авч үзэв:

- 1-р үе шат- гравитацийн аргаар баяжуулах,
- 2-р үе шат- гүйцээн баяжуулах үе шат.

1.4.2 Баяжуулах хэсгийн тоног төхөөрөмж

Угаан шигших төхөөрөмж

Угаан шигших төхөөрөмжийг Орос инженерүүд үйлдвэрлэсэн. Тус төхөөрөмж нь усны зарцуулалт бага, угсралт суурилуулалтын ажил хялбар, орчин үеийн металл авалт өндөр дэвшилтэт төхөөрөмж юм.

Хүснэгт 9. Сонгосон скруббер бутарын техникийн үзүүлэлт

№	Төхөөрөмжийн үзүүлэлт	Х.нэгж	
1	Хүчин чадал	м ³ /ц	100
2	Хүлээн авах хамгийн том мөхлөгийн хэмжээ	Мм	200
3	Диаметр	Мм	3200
4	Урт	Мм	7000
5	Жин	Тн	15
6	Цахилгаан хөдөлгүүрийн чадал	кВт	22
7	Суурилагдах тоо	Ш	1




Баяжуулах ширээний хүчин чадал, техникийн үзүүлэлт

Баяжуулах ширээний бүтээмж нь тэжээл дэх хүдрийн ширхэглэл, эрдсийн нягтын ялгаа, бүтээгдэхүүнд тавигдах чанарын шаардлага зэргээс хамаардаг. Угаан баяжуулах цех нь нэг баяжуулах ширээтэй байх ба шлюзийн баяжмалыг баяжуулж шлихийн алт гарган авах үүрэгтэй байна.


Хүснэгт 10. Баяжуулах ширээний техникийн үзүүлэлт

Д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Утга	Баяжуулах ширээний зураг
1	Баяжуулах ширээний марк	-	7-S	
2	Хүчин чадал	тн/өдөр	30-60	
3	Ашигтай талбай	м2	7.6	
4	Урт	мм	4,450	
5	Дамжуулах хэсгийн өргөн	мм	1,855	
6	Баяжмал хэсгийн өргөн	м	1,546	

Сэлэнгэ аймгийн Баянгол сумын нутагт орших “Сонор трейд” ХХК-ийн MV-001817, MV-006428 тоот тусгай зөвшөөрөлтэй “Цагаанчулуутын ам” алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2026 он

7	Тэжээлийн хэмжээ	мм	2	
8	Тэжээлийн нягт	%	25-30	
9	Ажиллагааны давтамж		45-48	
10	Ус зарцуулалт	тн/өдөр	80-150	
11	Хөдөлгүүрийн чадал	кВт	1.1	
12	Шаардлагатай тоо	ш	1	

Хүснэгт 11. Усны насосын техникийн үзүүлэлт

Д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Утга	
1	Марк	-	Д 320-506	
2	Хүчин чадал	м ³ /цаг	300	
3	Өргөлт	м	30	
4	Дугуйн эргэлт	эрг/мин	1450	
5	Хөдөлгүүрийн чадал	кВт	35	
6	Шаардлагатай тоо	ш	1	

1.5 Дэд бүтэц

Уурхайн тосгон, барилга байгууламж

Уурхайн барилга байгууламжид захиргааны байр, ажилчдын болон хоолны байр багтах бөгөөд эдгээр нь уурхайгаас урд зүгт 600м зайд байрладаг. Хотхон нь нам даралтын зуухаар дулаанаа шийдвэрлэсэн. Эдгээр барилга байгууламжийг 2018 онд ашиглалтад оруулсан. Эрүүл ахуйн шаардлага хангасан душ 1ширхэг, 00-н өрөө эрэгтэй, эмэгтэй тус бүр 1 ширхэг, угаалгын 1 өрөөгөөр тус тус тоноглогдсон контейнер 1 ширхэг байгаа ба ажиллах хүчинд тулгуурлан нэмэлтээр тооцоогоор шаардагдах амралтын сууцыг гэр сууц сонгон төлөвлөв.

Хотхоны нь дараах зохион байгуулалттай байна. ҮҮНД:

- 4 хүний багтаамжтай 7 өрөө
- 2 хүний багтаамжтай 3 өрөө
- Оффисын зориулалттай 1 өрөө
- Нэг доор 25 хүнд үйлчлэх хоолны газар 1 ширхэг
- ХАБЭА сургарт, зааварчилгаа өгөх 1өрөө

№	Нэр	Хийц бүтэц	Тоо хэмжээ, ш
1	Захиргааны байр	Сууц	1
2	Ажилчдын байр	Сууц, Гэр	8
4	Хоолны байр	Сууц	2
5	Халуун усны байр, Хувцас угаалга	Контейнер	1
6	Нийтийн бие засах газар	Контейнер	1
7	Эмнэлэг	Гэр	1
8	Хүнсний агуулахууд	Сууц	1






Төслийн хугацаанд ажилчдын хотхонд хамгийн ихдээ 34 хүн байрлах бөгөөд амрах байр, удирдлагын байр, засварын газар, гал тогоо, агуулах, угаалга, бие засах, шүршүүрийн байрууд байхаар төлөвлөсөн. Ажилчдын байр хүн амьдрахаар тохижуулсан сууц болон гэр байх бол шүршүүр, угаалга, бие засах газар мөн засаж тохижуулсан 40 тн-ын 1 ширхэг контейнер байна. Удирдлагын байр болон гал тогооны байр нь палкаар барьсан 1 давхар байр байна. Засварын газар болон харуулын байруудыг сэндвичэн хавтангаар байгуулах ба сэлбэг, тос тосолгооны материалын агуулах нь контейнерууд байна. Мөн шатахуун түгээх станцыг байгуулна.

Сэлэнгэ аймгийн Баянгол сумын нутагт орших “Сонор трейд” ХХК-ийн MV-001817, MV-006428 тоот тусгай зөвшөөрөлтэй “Цагаанчулуутын ам” алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2026 он

Д/д	Барилга, байгууламжийн нэр	Хэмж их нэгж	Хэмжээ	Тайлбар	
Уурхайн хотхон					
1	Уурхайн удирдлагын байр	м ²	36	2 өрөөтэй 1 давхар байр	
2	Ажилчдын сууц	ш	19	Тохижуулсан гэр	
3	Цайны газар, гал тогоо	м ²	54	Тохижуулж гэр	
4	Бие засах, халуун ус болон угаалга	м ²	60	40 тонны 2 контейнерыг холбон тохижуулна.	
5	Цэвэр ус хадгалах сав	ш	1	20 м ³ -ийн багтаамжтай сав байна.	
6	Ахуйн бохир хадгалах сав	м ²	10	Газар доор 20 м ³ -ийн багтаамжтай сав байгуулна.	
7	Сагсан бөмбөгийн талбай	м ²	450	Ажилчид чөлөөт цагаа өнгөрөөх	
Ил уурхай					
1	Засварын газар	м ²	100	Сэндвичээр 12x8 м хэмжээтэй байр барина.	
2	Шатахуун түгээх газар	м ²	15	50 тонны багтаамжтай сав	
3	Сэлбэгийн агуулах	м ²	15	20 тонны контейнер	
4	Тос тослох материал агуулах	м ²	30	40 тонны контейнер	
5	Харуулын байр	м ²	27	9 м ² талбайтай 3ш сэндвичин байр	
6	Уурхайг тойрсон хашаа	м	4,521	1.5 м-ийн өндөртэй торон хашаа	
Цахилгаан хангамж	Цагаанчулуутын ам алтны шороон ордыг эзэмшигч компани болох “Сонор трейд” ХХК нь Зүүн хараа сумын 110/6кВ-ын дэд станцаас 6 кВ-ын 1.4 км ЦДАШ-ыг барьж 2020 оны 11 сард ашиглалтад оруулсан байна. Тус 6 кВ-ын ЦДАШ-аас шороон ордын цахилгаан хэрэглээг хангана.				
	Уурхайн хотхоны цахилгааныг хотхоны хашаанд 100 кВА чадалтай трансформатор бүхий агаарын дэд станцаас тэжээх ба цахилгаан тасарсан үед ажиллах аваарын 100 кВА/200 кВт чадалтай дизель генератор суурилуулна. Уурхайн гэрэлтүүлгүүд, харуулын байр, засварын газар, шатахуун түгээгүүр, элс угаах төхөөрөмжүүдийн цахилгааныг 260 кВА чадалтай трансформатор бүхий агаарын дэд станцаас хангана. Төслийн нийт цахилгааны хэрэглээ Орд ашиглалтын 2 жилийн хугацаанд цахилгааны хэрэглээ 2,002.78 МВт ба жилд дунджаар 1,001.39 МВт байна. Төслийн нийт цахилгааны хэрэглээг дараах хүснэгтэд үзүүлэв.				
	Д/д	Үзүүлэлт	Ашиглалтын жил		Нийт
			1	2	
	1	Ил уурхай	96.82	96.82	193.64
	2	Элс угаан баяжуулах хэсэг	354.8	354.8	709.6
	3	Хотхон	549.77	549.77	1099.54
	Нийт		1,002.39	1,001.39	2,002.78
<i>Хүснэгт 12. Төслийн нийт цахилгааны хэрэглээ</i>					
Д/д	Хэрэглэгчийн нэр	Т.т-ийн нийт чадал, кВт	Байнга ажиллах т.т-ийн чадал, кВт	Хэрэглээний РТ, кВт	Цахилгаан хэрэглээ, мВт/жил
1	Ил уурхай	9.00	241.60	10.50	96.82

Сэлэнгэ аймгийн Баянгол сумын нутагт орших “Сонор трейд” ХХК-ийн MV-001817, MV-006428 тоот тусгай зөвшөөрөлтэй “Цагаанчулуутын ам” алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2026 он

	2	Элс угаан баяжуулах хэсэг	148.10	148.10	98.67	354.80
	3	Хотхон	46.10	79.50	59.63	549.77
	Нийт		203.20	469.20	168.79	1,001.39
Усан хангамж	Ашиглалтын 2 жилийн хугацаанд нийт 54 хүн ажиллах боловч уурхайд байрлах ажилчны тоо хамгийн ихдээ 30 хүн байна. <ul style="list-style-type: none">  Ахуйн усны хэрэглээ  Ил уурхай  Угаан баяжуулах цех 					
Аянгаас хамгаалах байгууламж	Уурхайн шатах тослох материалын агуулах болон засварын талбайг аянгын хамгаалалтын төхөөрөмж, түүнийг ашиглах журмын дагуу шатах тослох материалын агуулах ба засварын талбай нь аянгын шууд цохилтоос хамгаалагдсан байна. Шатах тослох материалын агуулах ба засварын талбайн аянгаас аянгаас хамгаалах байгууламж: Аянгын шууд цохилтоос хамгаалах зорилгоор аянга хүлээн авагч, гүйдэл зайлуулагч, газардуулгын голчтой савхан аянга зайлуулагчийг байрлуулан гүйцэтгэнэ. Аянга зайлуулагч нь өөр өөрийн газардуулгатай байна. ШТМ-ын агуулах болон засварын талбай нь анхдагч болон хоёрдогч аянгын цохилтоос хамгаалагдсан байх ёстой. Анхдагч аянгын цохилтоос хамгаалах аянга зайлуулагч нь талбайгаас зайтай тусдаа газардуулгатай байх ёстой. Газардуулга нь Ø-12мм, 5 м-ийн урттай төмөр хоолой буюу эсвэл 50*50*5 мм, 3 м-ийн урттай гурвалжин төмрөөр хийгдсэн байх ба газрын гүнд 0.8 м-т 40*4 мм ² төмөр туузан ил газардуулгатай холбогдсон байна.					

2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Газрын гадарга, хэвлий.

Баянгол сум нь газар зүйн мужлалын хувьд Хэнтий, Хянганы уулархаг их мужийн, Хэнтийн мужийн, бага Хэнтийн дэд мужийн захын тойрогт хамаарагдана. Талбайн урд ба хойд хэсгээр 1000-1080 м үнэмлэхүй өндөртэй, бөмбөгөр оройтой, дунд зэргийн хэрчигдэлтэй, 10-с дээш хэмийн налуутай уг гадаргууд кембри-ордовикийн метаморф терриген хурдас тархжээ.

Сэлэнгэ аймгийн Баянгол сум нь Улаанбаатар хотоос 156 км, Дархан-Уул аймгийн төвөөс 75 км, Сэлэнгэ аймгийн төвөөс 170 км зайд байрладаг. Улаанбаатар, Дархан, Сэлэнгэ чиглэлийн хатуу хучилттай авто зам ордын баруун талаар дайран өнгөрдөг. Баянгол сум нь газар зүйн мужлалын хувьд Хэнтий, Хянганы уулархаг их мужийн, Хэнтийн мужийн, бага Хэнтийн дэд мужийн захын тойрогт хамаарагдана.

Ашиглалтын хоёр талбай нь Сэлэнгэ аймгийн Баянгол сумын нутаг орших бөгөөд сумын төвөөс урд зүгт 18км, Улаанбаатар-Дархан- Сэлэнгэ чиглэлийн хатуу хучилттай замаас зүүн зүгт 3км, Зүүнхараа чиглэлийн хатуу хучилттай зам талбай дундуур дайран өнгөрдөг бөгөөд Улаанбаатар хотоос хойш 135км зайд байрладаг.

Уур амьсгал.

Сэлэнгэ аймаг нь Хангай, Хэнтийн уулархаг их мужид багтах бөгөөд Орхон, Сэлэнгийн савын газар хамрагдах 41.15 мян.км² нутаг дэвсгэртэй. Нутгийн зүүн урд болон баруун хэсэгт ДТД 1000-2113 м өндөрт өргөгдсөн, төв хэсэгт ДТД 600-1000 м өргөгдсөн гол мөрний өргөн хөндий талархаг байдал нь өвөрмөц уур амьсгалыг бүрдүүлдэг.

Тус аймаг нь Дархан-Уул аймгийг хүрээлэх бөгөөд хойд талаараа Оросын холбооны улс бусад талаараа Булган, Орхон, Төв, Хэнтий гэсэн дөрвөн аймагтай хиллэдэг.

Уур амьсгалын мужлалын хувьд чийглэг (хүйтэн зунтай, хахир өвөлтэй), чийглэгдүү (хүйтэвтэр зунтай, хахир өвөлтэй) болон хуурайдуу (сэрүүн зунтай, хахир өвөлтэй) бүсүүдэд оршдог (ШУА. 2009).

Монгол оронд агаарын жилийн дундаж температур, нийлбэр хур тунадасны газарзүйн хуваарилалт нутаг дэвсгэрийн янз бүрийн хэсэгт харилцан адилгүй. Зураг 7-д Цаг уур, орчны шинжилгээний газраас гаргасан Монгол орны жилийн агаарын дундаж температур, нийлбэр хур тунадасны нормын (1991-2020 оны) тархалтын мэдээллийг Сэлэнгэ аймгийн хэмжээнд таслан үзүүлэв.

Агаарын чанар.

Уурхайн бүсэд РМ 2.5 ширхэглэгтэй тоосны нягтшил 15-аас 28 мкг/м³, РМ 10 ширхэглэгтэй тоосны нягтшил 25-аас 42 гр/м³ байгаа нь Агаарын чанар Техникийн ерөнхий шаардлага (MNS4585:2025) стандартын хүлцэх агууламжаас нэн бага байна.

Дээрх үр дүнгээс үзэхэд гадаад орчны агаар дахь тоосонцрын хэмжээ “Агаарын чанар, техникийн ерөнхий шаардлага MNS4585:2016” стандартад заасан хүлцэх агууламжаас хэтрээгүй байна. Төслийн талбай дотор авсан дуу шуугианы хэмжээ мөн адил дБА байгаа нь MNS 4585:2016 Агаарын чанарын стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс бага байна. Эндээс үзвэл төслийн талбай орчны бүс нутаг газар ашиглалтын байдлаасаа шалтгаалан дуу чимээний түвшин ихсэж багасах нөхцөл байна.

Геологийн тогтоц ба геоморфологи.

Судалгааны талбай нь бүхэлдээ Хойд Хэнтийн металлогены бүсийн Бороо-Зуун модны хүдрийн дүүрэг Зуун модны хүдрийн зангилаанд Цагаан чулуутын, Нарийн хөндийн, Бороо голын гэх томоохон хагарлуудаар хянагдан байршдаг. Эдгээр хагаралтай перпендикуляр голдуу зүүн хойш чигтэй хагарал бутрал, гидротермаль хувирлын бүс, кварцын судлууд үүссэн байдаг. Үүнтэй уялдан хүдрийн дүүргийн хэмжээнд алтны орд илрэлүүдийн гарал үүслийг холбож тайлбарладаг. Эдгээр үндсэн орд, илрэлүүд нь тухай бүрдээ морфологийн төрх, шинжээсээ хамааран алтны шороон хуримтлалыг үүсгэсэн байдаг онцлогтой ба үүний нэг нь “Цагаан чулуутын алтны шороон орд юм.

Ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай нь Өвөр Байгалийн Даурын нурууны зүүн өмнөд хэсэг болох Хэнтийн уулсын баруун хойд хэсэгт оршино. Газрын гадаргууг хэлбэр дүрс, гарал үүсэл, онцлогоор нь тектоник-элэгдлийн, элэгдэл-хуримтлалын гэсэн хоёр төрөлд ангилсан. Тектоник-элэгдлийн гадаргуу нь нам өндөртэй толгодлог уулсаар илэрхийлэгдэх ба эдгээр нь дунд зэргийн хэрчигдэлтэй. Элэгдэл-хуримтлалын гадаргууд уулс хоорондын хотгор, эртний ба орчин үеийн гол хөндийнүүдийг хамруулсан. Талбайн урд ба хойд хэсгээр 1000-1080 м үнэмлэхүй өндөртэй, бөмбөгөр оройтой, дунд зэргийн хэрчигдэлтэй, 10-с дээш хэмийн налуутай уг гадаргууд кембри-ордовикийн метаморф-терриген хурдас тархжээ. Элэгдэл-хуримтлалын гадаргуугийн төрөл нь үндсэн чулуулгийн элэгдэл, зөөгдөл, хуримтлалын идэвхитэй үйл ажиллагаагаар үүссэн бөгөөд уул хоорондын хотос, налуу хажуутай хуурай өргөн хөндийнүүд, голын хөндий гэж ангилагдана. Уул хоорондын хотос ба налуу хажуутай хуурай өргөн хөндийн төрөлд гүвээ, толгодорхог болон нам уулс хөгжсөн бүсийн бэл хормойн хэсгээр үүсэж тархсан дөрөвдөгч, орчин үеийн сэвсгэр хурдсаар дүүргэгдсэн гадаргуу хамаарна.

Гадаргын болон газрын доор ус.

Төслийн талбай нь Хойд мөсөн далайн ай сав, Хараа голын сав газарт хамаарна. Талбайн хэмжээнд гадаргуугийн усан сүлжээ зонхилох бөгөөд эдгээрээс хамгийн том нь Бороо гол ба ашиглалтын талбайгаас хамгийн ойр цэг нь 5.8 км орчим зайтай байдаг.

Бороо гол: Бороо гол нь Налаг, Арцат, Хөх шанд, Ар толгой зэрэг 1300-1850 метр өндөр уулсаас эх авч, 1838 ам км талбайгаас усжих ба урдаас хойш чиглэн урсаж Хараа голд цутгана. Голын нийт урт 118.5 км ба адаг орчимд голын зүүн гар талд Их Даширын ам хөндлөн байрлалтай орших ба алтны үндсэн орд голоос 5-7 км-ийн зайтай байна. Бороо гол болон түүний цутгал гол, горхиуд түргэн урсгалтай, цэнгэг устай уулын голын ангилалд багтдаг. Бороо голын ёроолын хурдас нь элсэрхэг, шаварлаг бүтэцтэй. Бороо голыг алтны үйлдвэрлэл ялангуяа мөнгөн усны нөлөөнд ихээхэн өртсөн гэж үздэг. Бороо голд Шивэрт, Шаварт, Бөөрөлжүүт, Сүжигт, Арангат, Баянгол (ССаI, эрдэсжилт 69.8мг/л, хатуулаг 0.70 мг-экв/л), Зуунмод (Сса I, эрдэсжилт 73.5мг/л, хатуулаг 0.75мгэкв/л) зэрэг голууд цутгадаг ба Бороо гол нь Зүүнхараагаас доош Хараа голын зүүн гарын цутгал болдог.

Газрын доорх ус: Гидрогеологийн шавхалт туршилтын ажлын хүрээнд 1:5000 масштабын гидрогеологийн тойм зураг зохиож шавхалт туршилтын ажил болон хэмжилт дээжлэлтийн ажлыг “Мянганы Хас” ХХК-ийн гидрогеологич, инженер-техникийн ажилчид гэрээгээр хийж гүйцэтгэсэн. Энэхүү гидрогеологийн судалгааны ажлаар талбайн газрын доорх усны нөхцөл байдлыг тогтоох, судлах зорилгоор нийт 3 цооногт шавхалт, 14 цооногоос усны дээжлэлт хийж, хээрийн болон лабораторийн туршилтын үр дүн, тэдгээрийн боловсруулалтаар ордын гидрогеологийн нөхцлийг тодорхойлсон. Шавхалтын

ажлыг усажсан давхаргын усны ундарга, түвшин бууралт, тогтонги түшинг тодорхойлох зорилгоор 1л/с ундаргатайгаар 2 цагийн хугацаанд үргэлжлүүлж хийсэн.

Хөрсөн бүрхэвч.

Сэлэнгэ аймгийн Баянгол сумын нутагт орших “Сонор трейд” ХХК-ий эзэмшил алтны шороон орд орчмын бүс нутаг нь хээр бүхий экосистемтэй, д.т.д 920-1000 м үнэмлэхүй өндөртэй, нам уулс болон тэдгээрийн хоорондох ам хөндий бүхий газарт байрлах бөгөөд хөрсөн бүрхэвч нь Хүрэн шороон хөрсний хэвшинжид багтах ердийн Хархүрэн, Сайргархаг Хархүрэн төрлийн хөрснүүд зонхилон тархсан байна (Зураг 1). Эдгээр хөрс нь ерөнхий үржил шимийн түвшин дунд зрэг буюу ялзмагийн агууламж нь 2-5%, элэгдэл эвдрэлд тэсвэртэй, байгалийн аясаар нөхөн сэргэх чадамж сайн, элсэнцэр болон шавранцар механик бүрэлдэхүүнтэй байна. Судалгаанд хамрагдсан талбайгаас хөрсний дээж авсан цэгүүдийн байршлыг Зураг 1-т харууллаа. Төслийн талбайн хэмжээнд өнөөгийн байдлаар ямар нэгэн нөлөөлөлд өртөөгүй ердийн Хархүрэн хөрс 60%, бусад хөрс 30% тус тус тархсан байна. Мөн төслийн талбайд нөлөөлөлд өртөж эвдэрсэн газрууд 10% эзэлж байна. Хөрсний үржил шимийн түвшнийг тодорхойлдог голлох үзүүлэлт болох хөрсний ялзмаг, хөдөлгөөнт фосфор, кали болон хөрсний хими шинж чанарын үзүүлэлт болох хөрсний урвалын орчин (pH), карбонатын агууламж, хөрсний хялбар уусах давсжилт (ЕС) гэсэн үзүүлэлтүүдийг тодорхойлсон бөгөөд үзүүлэлт тус бүрийн үр дүнгийн талаар доор дэлгэрэнгүй тайлбарласан болно.

Төслийн талбайд өнөөгийн байдлаар хатуу хучилттай авто зам, технологийн зам талбай, кемп, техникийн нөхөн сэргээлт хийсэн уурхайн овоолго, хайгуулын үеийн нөлөөлөл зэрэгт өртсөн талбай 25.5 га буюу нийт талбайн 15% эзэлж байна.

Хортой хүнд металл гэдэгт дараах 6 хүнд металл багтана. Үүнд: Хар тугалга (Pb), кадмий (Cd), хром (Cr), цайр (Zn), никель (Ni), зэс (Cu) орно. Эдгээрээс Cd, Cr, Pb нь онцгой хортой, Co, Cu, Ni, Zn нь хортой био-идэвхт хүнд металлууд гэж үздэг. Онцгой хортой хүнд металлууд нь амьд организмд учруулах хор нөлөөлөл ихтэй, амьд организмд их хэмжээгээр орсон тохиолдолд өвчин үүсгэх улмаар үхүүлэх хүртэл аюултай байдаг. Харин хортой био-идэвхт хүнд металлууд нь хоруу чанарын хувьд онцгой хортой хүнд металлуудаас арай бага, тодорхой хэмжээгээр амьд организмд байх ёстой боловч амьд организмд их хэмжээгээр хуримтлагдвал эндемик буюу орогномол өвчин үүсгэдэг аюултай. Судалгааны үр дүнгээс харахад онцгой хортой хүнд металлуудаас кадми (Cd) маш бага буюу бараг илрээгүй байна. Бусад металлууд стандартын хүлцэх агууламжаас хэтрээгүй буюу хэвийн түвшинд байна.

Ургамлан бүрхэвч.

Ургамлын хээрийн судалгааг 2025 оны 4-р сард хийсэн бөгөөд мониторинг 3 цэгт бүлгэмдлийн бүтэц бүрэлдэхүүн онцлогоос харгалзан хэмжилт судалгааг явуулсан. Уг судалгаагаар төслийн талбайн болон түүний ойр орчимд 16 овогт хамаарах 35 орчим төрлийн 46 зүйл ургамлыг бүртгэгдсэн. Төрөл зүйлийн тоо бүрхэц, нягтшил нь тухайн жилийн цаг агаарын онцлогоос ихээхэн хамааралтай байдаг учир тухайн жилийн онцлог хээрийн судалгааны цаг үеэс хамаарч ургамлын төрөл зүйлийн тоо бага зэрэг өөрчлөгдөж болно.

Төслийн талбайд мод сөөг тарьсан бөгөөд модноос улиас, сөөгнөөс чацаргана, хайлаас, үхрийн нүд тарьсан. Улиас 5м орчим өндөртэй орчиндоо засан зохицож сайн ургаж

байсан. Чацаргана 1,5-2м өндөртэй, үхрийн нүд 50-70 см өндөртэй дасан зохицож ургасан. Хайлаас 50-70см өндөртэй зурваслан тарьсан бөгөөд 70% ургалттай ургаж байсан.

Хээрийн судалгаа болон боловсруулалтын явцад бүлгэмдэлд зонхилогч, дэд зонхилогч, ерөнхий тусгаг бүрхэц, халцгай газар, хүмүүнсэг ургамлын эзлэх хувь хэмжээг харгалзан үзэж Монгол орны хэмжээнд ургамлан нөмрөгийн талхлагдлыг тодорхойлох MNS 5546:2005 стандартын дагуу бэлчээрийг доройтлын зэргээр нь сул, дунд, хүчтэй доройтсон ба доройтоогүй хэвийн соргог бэлчээр гэж ангилдаг бөгөөд стандартын ангиллын дагуу тодорхойлсон. Судалгааны талбайн ургамлан нөмрөг хашаалсан нөлөөлөлгүй хялганат бүлгэмдэл сул зэрэг доройтсон, эвдэрсэн газар байгалийн аясаараа нөхөн сэргэж буй алаг өвст бүлгэмдэл нь их доройтсон байна. Барилга байгууламж, зам барьсан газрын ургамлан нөмрөг устсан тул хүчтэй доройтсон.

Амьтны аймаг.

Банников (1954)-ын амьтны аймгийн газарзүйн мужлалаар Дархан-Сэлэнгийн районын ихэнх нутаг “Монгол - Дагуурын хээр” -т, нутгийн зүүн өмнөд багахан хэсэг (Шарын гол орчим) “Хэнтийн уулархаг муж” - ийн тойрогт хамаардаг.

Тусгай хамгаалалттай газар нутаг.

Сэлэнгэ аймгийн нутагт нийт 3 УТХГ нутаг байрлана. Баянгол сумын нутагт нийт 8 ширхэг орон нутгийн ТХГН байрлах ба төслийн талбай нь Улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагтай давхцалгүй байна.

Түүх соёлын өв.

Аймгийн хэмжээнд 23-н түүх, соёлын үл хөдлөх дурсгал байна.

Нийгэм эдийн засаг.

Сэлэнгэ аймгийн Баянгол сум нь 1931 онд Богдхан уулын аймгийн Баатарвангийн хошууны Хөлий-Баян-Уул сумын суурин дээр Түнхийн аманд Хараа голын хөндийд байгуулагдан 1954 онд Мандах нэгдэл нэртэйгээр үйл ажиллагаа явуулж байгаад 1968 онд Баруунхараа САА болон өргөжин 1992 онд шинэ Үндсэн хуулиар Баянгол сум болон цэцэглэн хөгжиж байна. Баянгол сум нь Гринвичийн Зүүн уртрагаас 106004,56, хойд өргөрөгийн 48054,52-д оршдог. Монгол орны Хангай Хэнтийн уулархаг их мужийн Хэнтий нурууны дэд мужийн Хэнтийн баруун захын бэсрэг уулсын тойрогт хамаарагдана. Сэлэнгэ аймгийн Баянгол сум нь: Улаанбаатар хотоос 156 км, Дархан- Уул аймгаас 75 км Аймгийн төвөөс 170 км зайд байрладаг. Дархан-Уул аймгийн Хонгор сум, Шарын гол сум болон Төв аймгийн Сүмбэр сум, Сэлэнгэ аймгийн Мандал сумтай тус тус хиллэдэг. Улаанбаатар, Дархан, Сэлэнгэ чиглэлийн хатуу хучилттай авто зам дайран өнгөрдөг, мөн Төмөр замын зангилаатай Төвийн бүсэд хөгжих өндөр боломжтой сум юм.

Тус сум нь газар зүйн мужлалын хувьд Хэнтий, Хянганы уулархаг их мужийн, Хэнтийн мужийн, бага Хэнтийн дэд мужийн захын тойрогт хамаарагдана. Сэлэнгэ аймгийн нутгийн өмнөх хэсэгт Хараа, Бороо, Загдал, Баянгол зэрэг голуудын үзэсгэлэнт сав газар, ойт хээр, хээрийн бүсийн заагт оршино. Нутаг дэвсгэрийн хэмжээ 197.6 мян.га, хойд талаараа Дархан-Уул аймгийн Дархан, Шарынгол, зүүн хойд талаараа Сэлэнгэ аймгийн Мандал сум, өмнөд, баруун өмнөд талаараа Төв аймгийн Борнуур, Сүмбэр сум, баруун баруун хойд талаараа Сэлэнгэ аймгийн Орхон, Сайхан сумдын нутагтай тус тус хиллэнэ. Нутаг дэвсгэрийн нийт гадаргууд ой мод 21.2 мян.га, бэлчээр 120.8 мян.га, усан сан 0.3 мян.га, хадлан 29.5 мян.га, тариалан 17.6 мян.га талбайг эзэлнэ.

Нийслэл Улаанбаатар хотоос 154 км, Сэлэнгэ аймгийн төвөөс 170 км, Дархан-Уул аймгийн төвөөс 75 км, зэргэлдээх Мандал сумын төвөөс 35 км зайд оршдог. Тус сумын нутаг дэвсгэр дээгүүр олон улсын ач холбогдолтой төмөр зам 47 км, хатуу хучилттай авто зам 52.5 км дайран өнгөрдөг. Дэд бүтэц хөгжлийн ирээдүй сайтай, зам харилцаа чухал зангилаа юм.

Төслөөс орон нутгийн иргэдэд үзүүлэх нөлөөлөл

Төслөөс орон нутгийн хүн амд үзүүлэх нөлөөллийг ажил эрхлэлт, амьжиргаа, шилжин хөдөлгөөн, нүүлгэн шилжүүлэлтийн хувьд авч үзлээ.

Алтны шороон ордыг ашиглах төсөл хэрэгжсэнээр сумын түвшинд ажил эрхлэлт, үйлдвэрлэл, үйлчилгээ нэмэгдэж үүнийг дагаад иргэдийн амьжиргаанд эерэг нөлөөлөл үзүүлнэ.

Төслөөс орон нутгийн эдийн засгийн хөгжилд үзүүлэх нөлөөлөл

Тус төсөл хэрэгжсэнээр улс, орон нутгийн төсөвт татвар болон хураамж хэлбэрээр улсын төсөвт төлнө. Төсөл хэрэгжсэнээр нөлөөллийн бүсийн сумын эдийн засагт дараах байдлаар шууд болон шууд бус эерэг нөлөөллүүд үзүүлнэ. Эдгээрт:

- Ажил эрхлэлт нэмэгдэх
- Уурхайд бүтээгдэхүүн, үйлчилгээ нийлүүлснээр орлого нэмэгдэх, иргэдийн амьжиргаа сайжрах
- Сумын орлогын эх үүсвэр бэхжих
- Бизнес хөгжихөд таатай орчин бүрдэх

Төслийн үйл ажиллагаанаас үзүүлж болзошгүй эрүүл мэнд, аюулгүй байдлын ерөнхий

3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Хүснэгт 13. Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт

Байгаль орчны үзүүлэлт	Шууд	Шууд бус	Өөрөөр	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд эрэг	Бага зэрэг
1. Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт										
Газрын доорх урсцын өөрчлөлт			x							
Гадаргын урсцын өөрчлөлт			x							
Ургамлын бүтцийн өөрчлөлт	x				x					x
Хөрсний элэгдэл, эвдрэл	x				x					x
Зэрлэг амьтдын орон зайн өөрчлөлт			x							
Уур амьсгалын (бичил) өөрчлөлт			x							
2. Байгалийн нөөц ашиглалт										
Газрын гадаргын нөөц баялаг			x							
Бэлчээрийн байдал			x							
Эрдэс түүхий эдийн нөөц			x							
Эрчим хүчний нөөц			x							
3. Байгаль, орчны өөрчлөлт										
Газрын доорх усны чанар, хэмжээ			x							
Гадаргын усны чанар хэмжээ			x							
Агаарын бохирдол			x							
Хөрсний бохирдол			x							
Төслийн үйл ажиллагаанаас ялгарах бохирдуулагч бодис хүний эрүүл мэндэд нөлөөлөх			x							
Дуу чимээ, шуугианы нөлөө			x							
4. Байгалийн өнгө төрх, түүх, соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор										
Байгалийн үзэсгэлэнт өнгө төрх өөрчлөгдөх			x							
Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх			x							
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх			x							
Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх			x							
Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх			x							
5. Нийгэмд үзүүлэх нөлөө										
Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх		x			x				+	
Үйлчилгээний салбарын ү/а-нд нөлөөлөх		x			x					+

Хүн амын орлого өөрчлөгдөж, нэмэгдэх		x			x			+	
Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх			x						
6. Эдийн засагт үзүүлэх нөлөө									
Татварын орлого өөрчлөгдөх	x				x		x		+
Орон нутгийн орлого нэмэгдэх	x				x		x		+
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	x				x		x		+
Ажлын байр нэмэгдэх	x				x		x		+
Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	x				x		x		+
7. Бусад нөлөөлөл									
Бохир ус хөрсөнд нэвчиж, хөрс ба грунтын усыг бохирдуулах			x						

Төслийн болзошгүй сөрөг болон эерэг нөлөөллийн хэлбэр, хугацаа, эрчмийн үндэслэлийг дараах байдлаар гаргасан болно. Үүнд:

Төслийн болзошгүй сөрөг болон эерэг нөлөөллийн хэлбэр, хугацаа, эрчмийн үндэслэлийг дараах байдлаар гаргасан болно. Үүнд:

Шууд нөлөөлөл:

- Төслийн барилга байгууламжийн нөлөөгөөр биет хэмжээгээр хөрс, ургамлан бүрхэвч үүсмэл хэлбэршлээр солигдож, шууд, урт хугацаанд сөрөг нөлөөлнө;
- Дэд бүтцийн хөгжилд эергээр, урт хугацаагаар нөлөөлнө;
- Орон нутгийн орлого, ажлын байр нэмэгдэх зэрэгт төслийн үйл ажиллагаа явагдах хугацаанд болон цаашид эергээр нөлөөлнө;

Шууд бус нөлөөлөл:

- Цаашид салбарын үйл ажиллагаанд урт хугацаанд эерэг нөлөөлнө;

Хүчтэй нөлөөлөл:

- Болзошгүй нөлөөллийн үнэлгээ хийх явцад төслийн зүгээс хүчтэй нөлөөлөх нөлөө байхгүй байна.

4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАМРАХ ХҮРЭЭ

Зорилго: Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай шинэчилсэн хуулийн 9-р зүйлд зааснаар Байгаль орчны менежмент төлөвлөгөө (БОМТ) нь нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан баримт бичиг бөгөөд Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОННУ)-ний салшгүй хэсэг юм.

Байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд болон хүний эрүүл мэнд, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулахад зайлшгүй хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх;

Төслийн үйл ажиллагаанаас агаар, хөрс, усан орчин болон ажлын байрны нөхцөлд хэрхэн нөлөөлж байгаа талаар хяналт шинжилгээ явуулах арга хэмжээг төлөвлөх;

Сэлэнгэ аймгийн Баянгол сумын нутагт орших “Сонор трейд” ХХК-ийн MV-001817, MV-006428 тоот тусгай зөвшөөрөлтэй “Цагаанчулуутын ам” алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн БОМТ-г БОАЖЯ-ийн сайдын 2019 оны А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” боловсруулсан болно.

Уурхайн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний судалгаагаар тогтоогдсон гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, тухайн жилийн уурхайн ашиглалтын төлөвлөгөөтэй уялдуулсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг амжилттай биелүүлэн ажилласан.

Хүснэгт 14. 2026 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал

№	Ажлын нэр	Зардал, мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	15,450,000.00
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	50,000,000.00
3	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөний зардал	5,000,000.00
4	Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох төлөвлөгөө	-
5	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
6	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	6,925,000.00
7	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	7,250,000.00
